

ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГ ХАНГАЛТТАЙ ЯВУУЛААГҮЙ НЬ ХОХИРОГЧДОД НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛӨХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн нэр: Commissioner of Police of the Metropolis v DSD and another [2018] UKSC 11

Шүүхийн шийдвэрийн огноо: 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгчид нь 2003 ба 2007 онуудад таксины жолоочийн бэлгийн халдлагад өртөж, цагдаагийн байгууллагад гомдол гаргасан боловч цагдаагийн байгууллагаас нотлох баримт хангалтгүй гэх үндэслэлээр таксины жолоочид холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгээгүй байна. Улмаар уг гэмт хэргийн нийт хохирогчдын тоо 19 хүрснээр нэхэмжлэгчдийг хохирогчоор тогтоон, хэрэг үүсгэж шалгасан байна.

Харин хохирогч эмэгтэйчүүд Метрополисын цагдаагийн комиссарыг Европын хүний эрхийн конвенц -ын 3 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах үүргээ зөрчсөн хэмээн үзэж, учирсан хохирлоо гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ. гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Дээд шатны шүүх²-ээс:** Метрополисын цагдаагийн байгууллага нь нэхэмжлэгчдийн гаргасан гомдолд хангалттай мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй байна. Ийнхүү мөрдөн шалгах ажиллагааг хангалтгүй явуулж, хэрэгтнийг тавьж явуулсан нь Европын хүний эрхийн конвенцын 3 дугаар зүйлд заасан “Хэнийг ч эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг гутаан доромжлон харьцаж, шийтгэж болохгүй” гэснийг зөрчсөн болно хэмээн дүгнэж нэхэмжлэгчдэд нөхөн төлбөр олгуулахаар шийдвэрлэсэн байна.
- Давж заалдах шатны шүүхээс:** Дээд шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
- Метрополисын цагдаагийн комиссар давж заалдах гомдолдоо:** “Европын хүний эрхийн конвенцын 3 дугаар зүйлээр эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан талаарх хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах үр дүнтэй механизм бий болгохыг төрөөс шаарддаг. Өөрөөр хэлбэл, уг заалт нь цагдаагийн байгууллагын өдөр тутам хэрэгжүүлэх албаны чиг үүргийг

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.supremecourt.uk/cases/docs/uksc-2015-0166-judgment.pdf>

² Англи Улсын дээд шатны шүүх (англ. High court) нь уг маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн байна.

зохицуулсан заалт бус төрд үр дүнтэй системийг бий болгох үүрэг оногдуулсан заалт юм. Гагцхүү мөрдөн шалгах албаны чиг үүрэг яригдах нэг нөхцөл бол төрийн албан хаагч дээрх хүний эрхийн зөрчлийг үйлдсэн байх тохиолдол бөгөөд энэ тохиолдолд Цагдаагийн байгууллага дахь өргөдөл гомдлын комисс зэрэг хараат бус хяналтын байгууллага уг үүргийг хэрэгжүүлэх боломжтой” гэх агуулга бүхий гомдлыг хяналтын шатны шүүхэд гаргажээ.

4. **Хяналтын шатны шүүхээс** тус хэргийг хянан хэлэлцээд “Европын хүний эрхийн конвенцын 3 дугаар зүйл *“Хэнийг ч эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг гутаан доромжлон харьцаж, шийтгэж болохгүй”*” гэсэн зохицуулалт нь энэ төрлийн хүний эрхийн зөрчлийг үр дүнтэйгээр мөрдөн шалгах идэвхтэй үүрэг /англ. *positive obligation*/³-ийг агуулдаг. Тодруулбал, уг заалтын дагуу төрөөс мөрдөн шалгах ажиллагааг зохистой явуулах системээр хангахаас гадна цагдаагийн алба 3 дугаар зүйлд холбогдох зөрчлийг бүрэн дүүрэн, үр дүнтэй мөрдөн шалгах чиг үүрэгтэй юм. Ийнхүү мөрдөн шалгах чиг үүрэг нь хууль зүйн системийн гажуудлаар хязгаарлагдах ёсгүй” хэмээн дүгнэж давж заалдах гомдлыг хангахаас татгалзаж шийдвэрлэжээ.

---o0o---

³ “Идэвхтэй үүрэг /англ. *positive obligation*/ гэдэг нь хүний эрхийг хангах зорилгоор шаардлагатай арга хэмжээ авах үүрэг юм.” Jean-François Akandji-Kombe, *Positive Obligations under the European Convention on Human Rights*, Human rights handbooks No. 7, (2007), 7, <https://rm.coe.int/168007ff4d> (Сүүлд үзсэн:2024.09.16).